

БАТЛАВ: ДӨРВӨЛЖ/ ОНОСААТГАН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ С.ТУВШИНДЭЛГЭР



### Ажлын тусгай хувцасны техникийн тодорхойлолт

№	Нэр төрөл	Хэмжих нэгж	Тоо ширхэг
1	Зуны даавуун өмд, цамц	Хос	99
2	Бомбор /өмд цамц/	Хос	60
3	Битүү комбинзон ажлын хувцас /Өвдөг, тохой нэмэлт оруулгатай женсен/	Хос	12
4	Галд тэсвэртэй женсен ажлын хувцас/ галд тэсвэртэй нэмэлт оруулгатай, юудэнтэй/	хос	60

#### 1.Үндсэн шаардлага

Ажлын тусгай хувцасны дизайн, үйлдвэрлэл, материал нь дараах шаардлагыг хангасан байна. Үнд:

1.1. Ажлын тусгай хувцас нь “Ажлын тусгай хувцас-ерөнхий шаардлага MNS 13688:2000” Монгол улсын стандарттай дүйцэхүйц шаардлагыг хангасан байна.

1.2. Тендерийн баримт бичигт заасан тооны хувцасны чанар нь захиалагчид 1 ком загварын хувцаснаас материал, чанар (гараар мэдрэхэд ялгаагүй), өнгө хийцийн хувьд ялгаагүй, өнгө зөрөөгүй адил байна.

1.3. Захиалагчид нийлүүлэх бараа нь үйлдвэрлэлийн болон механик ямар нэгэн тэмтэл согоггүй, заасан өнгөнөөс зөрөөгүй байна.

1.4. Бүх хувцасны материал нь олон улсын холбогдох стандарт хангасан, хүний биед эвтэйхэн, харшил үүсгэх арьс салстыг цочроо үйлдэлгүймөн шатахад барьж наалддаггүй болохыг нотлох мэргэжлийн байгууллагын сертификат, тодорхойлолт (дүгнэлт)-тэй байна.

1.5. Хувцасны материал, бүрдэл хэсгүүд нь хүнд саад болохооргүй, ус үүр, тос масло нэвтрүүлэхгүй байна.

1.6. Бүх хувцас хэрэгслийг хийсэн эсхүл түүнд орсон материал бүр нь хүний биед сөрөг нөлөөгүй, аливаа цочрол, шархлаа үүсгэхээргүй, харшил өгөхгүй, биеийн хөлстэй урвалд орох чанаргүй зориулалтын хувцасны материалаар хийгдсэн байна.

1.7. Бүх хувцасны дизайн нь хөдөлмөрийн нөхцөл, биеийн хөдөлгөөний онцлогт тохирсон байх.

1.8.Бат бөх хийгдсэн эдийн засгийн үр ашигтай байх ба ажлын хувцасны бүх чимэг оёдлыг 1 см –т 4-5 ,дотор холбох хавсарсан оёдлыг 1смт 3-4 хатгацтайгаар,сайн чанарын мяндсан утсаар оёно.

1.9.Үйлдвэрлэлийн болон гадны нөлөөлөөс хамгаалах чадвар сайтай байна.Тэмөр буюу металл гадаргуутай хүрэлцэх үед хувцас нь цахилгаанжихгүй,үрэлтэд гэмтэх,цооролт өгөхгүй.

1.10.Хувцасны материал нь хөвөн даавуу 100% эсвэл 65% полиэлистр,35%хөвөн даавуун байна.

1.11.Ажлын тусгай хувцасыг үйлдвэрлэснээс хойш 2- оос доошгүй жил ердийн нөхцөлд хадгалсны дараа тэдгээрийг ашиглах боломжтой байх.

1.12.Ажлын хувцасанд угаалга,арчилгааны шошго,хувцасны хэмжээ,үйлдвэрлэгчийн нэр,арчилгааны заавар болон бусад шаардлагатай мэдээлийг хувцас тус бүр оёж тогтоосон байна.

1.13.Хувцасны масс нь түүнийг өмсөж байгаа хүний ая тухыг хангах ба биенийн хүчний ачааллын багасгахын тулд бололцооны хирээр бага байна.

1.14.Хязгаарлагдмал ажлын талбай буюу хөдөлгөөнтэй машин техник,элементүүдэд орооцолдохгүй байх.

1.15 Түүхий эд материалыг биет байдлаар үзэж шалгах

### 2.Ажлын тусгай хувцасны ангилал

Ажлын байр,хөдөлмөрийн нөхцлөөс хамааруулж ажлын тусгай хувцсаар хангагдах ажилтнуудыг 2 хэсэгт хуваана.

Д/д	Мэргэжлийн ангилал	Албан тушаалын нэр		
		Удирдлага	ИТА	Ажилчид
1	Ажлын тусгай хувцсаар хангах	Компанийн удирдлага, алба хэлтсийн дарга	Хэсгийн ахлагч нар, ИТА-нууд	Цех хэсгийн ажилчид
2	Ажлын тусгай хувцсаар хангах			Оффисийн ажилтнууд

### 3.Ажлын тусгай хувцасны өнгө.

3.1.Ажлын байр албан тушаал,хөдөлмөрийн нөхцлөөс шалтгаалж ИТА-чид болон ажилчдын хувцасны өнгө өөр байна.

	Зуны хувцас
--	-------------

Мэргэжлийн ангилал	Үндсэн	Нэмэлт /оруулга/	Өмд
Ажлын тусгай хувцсаар хангах /Удирдлага болон ИТАжилчид/	Улаан	Саарал	Саарал
Ажлын тусгай хувцсаар хангах /Ажилчин /	Улаан	Хөх цэнхэр	Хөх цэнхэр

#### **4.Ажлын хувцасны загвар,хийцийн шаардлага**

##### **ИТА ажлын өмд,цамц/эрэгтэй,эмэгтэй/хавар намрын бомбор**

Үндсэн өнгө:/Улаан саарал/Зураг 1

4.1.Хөдөлгөөнд саад болохгүй байх буюу суга,арын хэсэгт хүний биеийн хөдөлгөөнийг хязгаарлахгүй байх нөхцлийг хангасан хийц оруулах

4.2.Цамцны зүүн гарын хэсэгтээ цахилгаантай халаас, мөн үзэгний оруулгатай байна ташаандaa гадна хажуу талаа хагас уутан хэлбэртэй халаасандaa улаан өнгийг оруулаг оруулна.Мөн зүүн энгэрий дээд талд байгууллагын эмблем  байна.

4.3.Арнуруунд болон ханцуйны үзүүрт хэсэгт /шууны хэсэг/гэрэлтдэг оруулагатай байна.Мөн ар нуруунд манай байгууллагын нэрийг /ДӨРВӨЛЖ КОМПАНИ/гэж бүтнээр бичнэ.

4.4.Хувцасны хийцэд хувцасны доорхи давхаргын бичил орчны хэвийн байдлыг дэмжих элементүүд оруулна.Хөлс ихээр ялгардаг хэсгүүдэд салхивчны нүх,дотор талд нь зориулалтын төр хийх

4.5.Өмд нь ердийн шулуун загвартай,Ташаанд хагас уутан хэлбэртэй халаастай байна.

4.6.ИТА ажлын хувцасны баруун энгэр дээр инженерүүдийн нэр байрлуулна./Нэрийг авч болдогоор хийлгэнэ.

##### **Ажилчдын ажлын өмд,цамцны загвар./эрэгтэй эмэгтэй ажилтан/**

Үндсэн өнгө:/Улаан хөх цэнхэр/ Зураг 3-т

4.2.1.Хөдөлгөөнд саад болохгүй байх буюу суга,арын хэсэгт хүний биеийн хөдөлгөөнийг хязгаарлахгүй байх нөхцлийг хангасан хийц оруулах

4.2.2.Цамц нь ердийн шулуун загвартай,энгэр нь дан зөрлөгтэй товчоор товчлогдоно.

4.2.3.Цамцны энгэрийн дээд хэсэгтээ тагтай халаастай.Ташаандаа эзлэхүүнтэй тагтай,ил халаастай.Халаас гүн бөгөөд доод талын монжатканд бэхлэгдэж оёгдсон байх.Энгэрт зүүн кармайны дээд талд байгууллагын эмблемийг  байрлуулах.

4.2.4.Ар нуруу болон ханцуйны дээд хэсэгт /бугалганы хэсэгт/гэрэлтдэг оруулгатай байна.Ар нуруунд байгууллагын нэрийг бүтэн бичих/ДӨРВӨЛЖ КОМПАНИ/

4.2.5.Цамц нь ердийн шулуун загвартай,энгэр нь дан зөрлөгтэй товчоор товчлогдоно.

4.2.6.Цамцны энгэрийн дээд хэсэгтээ тагтай халаастай.Ташаандаа эзлэхүүнтэй,тагтай,ил халаастай.Халаас гүн бөгөөд доод талын монжатканд бэхлэгдэж оёгдсон байх.

4.2.7.Ар нуруу болон ханцуйны дээд хэсэгт /бугалганы хэсэгт/гэрэлтдэг оруулгатай байна.

4.2.8.Цамц нь төмөр болон аминопласт товчтой байна.Товчны нүхний урт нь уг бүтээгдэхүүнд хадагдах товчны диаметрээс 0,2-0,5 см илүү байна.Товчний нүхийг заавал тусгай зориулалтын машинаар гаргаж,цоолсон байх ба төгсгөлийг бөхөлсөн байна.

4.2.9.Хувцасны хийцэд хувцасны доорх давхаргын бичил орчны хэвийн байдлыг дэмжих элементүүд оруулна.Хөлс ихээр ялгардаг хэсгүүдэд салхивчны нүх,дотор талд нь зориулалтын тор хийх гэх мэт.

4.2.10.Өмдний өвдөг болон арын суудлын хэсэгт давхарлагатай,өвдөгний доод шуу хэсэгт гэрэлтдэг цацуулагчтай байна.Ташаанд орсон хагас уутан хэлбэртэй халаас,хажуу хэсэгт эзэлхүүнтэй тагтай байна.

4.2.11.Цээжний бүсэлхийн өгзөгний бүслүүр дээрх чөлөөт хөдөлгөөний сулын нэмэлтийн хэмжээ нь амьсалах,цусны эргэлт,хувцасны доорх давхаргын агаарын хөдөлгөөн,биенийн хөдөлгөөний чөлөөт байдлыг хангаж байх ёстой.

4.2.12.Хувцасны суга,өмдний суудлын оёдол,халаас мөрний оёдолгэх мэт ачаалалд их өртдөг зангилаа хэсгүүдийн оёдлыг бат бөх болгох зорилгоор нэгтгэх оёдлоос гадна дан болон хос ил оёо хийнэ.

## Зураг 1



### ***Галд тэсвэртэй Галч, Гагнуурчны хувцас буюу женсен өмд цамц/эрэгтэй/***

4.3.1. Галч Гагнуурчны хувцас нь Галд тэсвэртэй хувцас EN ISO 11612:2015, Гагнуурын хувцас EN ISO 11612:2015 стандартын шаардлагыг хангасан байна.

4.3.2. Ганнуурчны женсен өмд цамцны материал нь шаталтад тэсвэрлэлт сайтай байх, зориулалтын түрхлэгтэй байх, цахилгаан нумаас гэрэлтсэн дулаанаас, хайлсан металлын жижиг цацраг, дөлтэй богино хугацаанд холбоо барихаас хамгаалах зориулалттай, ердийн гагнуурын нөхцөлд шууд гүйдлийн ойролцоогоор 100 вольт хүчдэлтэй үед шууд цахилгаан дамжуулагчтай богино хугацааны холбооны барих замаар цахилгаани цочролыг багасгадаг байна.

4.3.3. Галч, гагнуурчны хувцасны цамцны зах босоо, биед саад болохооргүй загвар хийцтэй хөнгөн байна.

4.3.4. Энгэрийн дээд хэсэгтээ тагтай халаастай. Ташаандаа эзлэхүүнтэй ил халаастай. Энгэрийн халаасны зүүн талд байгууллагын эмблемийг байрлуулах.

4.3.5. Энгэр, ар нуруунд гэрэл ойдог түүз болон саарал өнгийн оруулгатай. Ар нуруунд байгууллагын нэрийг бүтнээр бичих. /ДӨРВӨЛЖ КОМПАНИИ/

4.3.6. Цамц нь юүдэнтэй байна мөн шуу суга хэсэгтээ галд тэсвэртэй арьсан нэмэлт оруулгатай байна.

Зураг 2



Техникийн тодорхойлолт бичсэн: ХАБЭА-н албаны дарга Г.Төрболд

A handwritten signature in black ink, likely belonging to G. Törbölđ, the manager mentioned in the text above.